



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/443

Есөнбулаг

Согтууруулах ундаа худалдах  
түүгээр, үйлчилгээ эрхлэхийг  
түр хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэг, 70.1.1 дахь заалт, 70.1.2 дахь заалт, 70.1.3 дахь заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн санал авах үйл ажиллагаатай холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс 29-ний өдөр хүртэл аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг, 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг тус тус түр хориглосугай.

2. Хориглосон өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Н.Мэндбаяр)-т, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Мягмарсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О АМГАЛАНБААТАР

